

Баянтал сумын Засаг даргын Тамгын газрын
05 дугаар сарын тайлан

2022.05.23

УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН АЖЛЫН ХҮРЭЭНД:

1. 2022 оны 04 дүгээр сарын 28-ны өдөр Засаг даргын зөвлөлийн ээлжилт 05 дугаар хуралдаанаар 4 асуудлыг хэлэлцэн шийдвэрлэв. Үүнд Хог хаягдлын 50 сая төгрөгийн зарцуулалт төлөвлөгөөг батлуулах, статистикийн тэргүүний ажилтан цол тэмдэгт албан хаагчийн материалыг хүргүүлэх, Тэрбум модны хүлэмжийг хуваарилах асуудлыг шийдвэрлэв.




Сумдын анхан шатны статистикийн ажилтнуудын зөвлөгөөнд 6 албан хаагч хамрагдав.



Авлигатай тэмцэх газраас ирүүлсэн албан тоотын дагуу: Сум хөгжүүлэх сангаас зээл аваад төлөөгүй иргэдийн өрийг барагдуулах ажлын хүрээнд 2013, 2015 оны 2 зээлдэгчийн баримтыг Говьсүмбэр аймгийн Иргэний хэргийн анхан шатны шүүхэд шилжүүлсэн, 1 иргэний өрийг бүрэн төлүүлсэн, 3 иргэний зээлийг төлөлтийн хуваарьт нь оруулж хэвийн зээлдэгч болсон.

Ахуй үйлчилгээний талаар төрөөс баримталж буй бодлого, ажлын байрны стандарт сэвдээр Аймгийн ХХААГазраас зохион байгуулсан сургалтанд сумаас 5 иргэн хамрагдсан. Сүмбэр зоогийн зоотехникч Дэлгэрмөнхийн хамт 15 малчин өрхийн 18 ямаанаас ноолуурын дээж авч УБ хотын мал эмнэлгийн эрдэм шинжилгээний хүрээлэнгийн лабораторит илгээж ноолуурын чанар тодорхойлуулахаар бэлэн болгосон. 1 ямааны ноолуурын шинжилгээ 22000 төг байна. Түүнийг малын эздээр нь төлүүлж байна.



Байгаль орчин:

Төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжийн албан хаагчдыг хамруулж тус бүр 5-аас доошгүй мод тарих албан үүрэг өгч 2022.05.04-ний байдлаар 150 мод тариалсан дүнтэй байна. Мод, төмс хүнсний ногоо тариалах сонирхолтой 6 иргэнийг модны суулгац, хүнсний ногооны үрийн үзэсгэлэн худалдаанд оролцон гарын авлага, арга зүйн зөвөлгөөгөөр хангагдсан.

Газар тариалан:

Хаврын тариалалтын ажил эхэлж ногоочид талбай цэвэрлэгээ, хөрс боловсруулалтын ажлаа дуусаж байна. 2022.05.04-ний байдлаар 0.1 га талбай 2 төрлийн таримал, 300 ш үрсэлгээ бэлтгээд байна. Тус ажлын хүрээнд 15 иргэний талбайд нь очиж арга зүйн зөвөлгөө өгч ХААХҮЯ-аас хөнгөлөлттэй нөхцлөөр олгож буй 0.2 кг үрийг 8 иргэнд олгоод байна



2022 оны 05 дугаар сарын 06-07-ны өдрүүдэд Төрийн албан хаагчид сумын төвийн болон төв зам дагуу хог хаягдлыг цэвэрлэв. Нийт Шатахуун 100,7 л шатахуун зарцуулж, хог төвлөрсөн хогийн цэг 2, сумын төвийн 7 байрны орчин, үйлчилгээний 3, нийтийн эзэмшлийн 50 га газрын 5 тонн хог хаягдлыг цэвэрлэсэн.



ЕБСургууль:

- 2022 оны 04 сарын 22-нд сургуулийн 6-9 дүгээр ангийн сурагчдын дунд холимог гар бөмбөгийн тэмцээнийг зохион байгуулан ажилласан. Тэмцээнд 6-9 дүгээр ангийн 38 сурагч хамрагдсан. Уг тэмцээнийг сургуулийн захиргаа, 1-р багийн малчин Г.Баярмагайгийн гэр бүлтэй хамтран зохион байгуулсан.
- 2022 оны 04 дүгээр сарын 24-ний өдөр сургуулийн нийт эцэг эхчүүдийн өдөрлөгийн зохион байгуулсан. Өдөрлөгөөр эцэг эхчүүдийн дунд гар бөмбөгийн тэмцээн зохион байгуулсан бөгөөд нийт 10 баг оролцож 1-р байр 7а анги, 2-р байр 5а анги, 3-р байр 4а ангиуд тус тус шалгарсан байна.
- Зүүн бүсийн өсвөрийн хөл бөмбөгийн Сүхбаатар аймагт зохиогдсон тэмцээнд сургуулийн 4 сурагч аймгийн нэгдсэн багтай хамтран тоглож багаараа 2-р байранд шалгарсан байна.

- 2022 оны 05 дугаар сарын 02, 04, 05-ны өдрүүдэд 1-3 ангиудын тайлант уншлагын бага ангийн заах аргын нэгдэл сургуулийн захиргаатай хамтран эцэг эхчүүдийг оролцуулан зохион байгууллаа.

СӨБоловсрол:

- 2022 оны 05 дугаар сарын 5-ны өдөр аймгийн хэмжээний СӨБ-н хүүхдүүдийн дунд зохион байгуулагдсан “Замын хөдөлгөөн – Цагаан толгой” тэмцээнд амжилттай оролцлоо.
- 2022 оны 04 дүгээр сарын 21-29-ний өдрүүдэд “Эрүүл мэнд”, “Ээлжит хичээлийн цахим контент боловсруулах арга зүй”, “Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн 2022 оны Улсын үзлэг тооллогод хэрхэн бэлдэх вэ?”, “ESIS цахим системд статистикийг хэрхэн бүртгэх вэ?”, “Удирдах ажилтан, багш нарын ёс зүй, харилцаа хандлага, EQ чадвар”, “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн дэмжлэгийн багийн сургалтанд тус тус давхардсан тоогоор бүлгийн 12 багш, 1 эцэг эхийн төлөөлөл хамрагдсан.



Эрүүл мэндийн төв:

“Эрүүл мэнд үндэсний баялаг” урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэг аяны нээлт Монгол Улсын засгийн газрын 2020 оны 203 дугаар тогтоол, ЭМДЕГ үндэсний зөвлөлийн 2022 оны 06 дугаар тогтоол, ЭМСайдын 2022оны А/139 дүгээр тушаал, мөн сайдын 2022 оны 04 сарын 21-ны өдрийн 03 тоот албан даалгаварын чиглэлээр Урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэг, үзлэг, шинжилгээ, оношилгооны үйл ажиллагааг албан ёсоор эхлүүллээ.

2022 оны 05 дугаар сарын 01 -ний өдөр нээлтийн үйл ажиллагаагаа зохион байгуулж 0 - 17 насны хүүхдүүдийн үзлэг хийлээ.

Соёлын Төв:

- - Соёл урлагийн арга хэмжээ-2, сургалт, тайлант хурал-2, нийт 4 арга хэмжээг техник хэрэгслээр ханган хамтран ажилласан.
- Боржигин өв музейгээс арга зүйн зөвлөгөө авч Лүн, Лүнгийн хадат зэрэг газруудаар хээрийн судалгааг хамтран зохион байгууллаа. Мөн судалгааны явцад шинэ чулуун зэвсгийн үед хамаарагдах олдворуудыг судлан илэрүүлж, шинэ чулуун зэвсгийн үеийн талаар тайлбар танилцуулгыг хийж, арга зүйн зөвлөгөө авсан.
- Соёлын төвийн бүжгийн сургалтанд 19 хүүхэд, хөөмийн дугуйланд 2 хүүхэд хамрагдан хичээллэж байна.



- Баянтал сумын төрийн сангийн цаг үеийн мэдээ
- 2022 оны 04 дүгээр сарын 31-ний байдлаар 61,858.0 мянган төгрөг төлөвлөгөө батлагдсанаас гүйцэтгэлээр 40,316.4 мянган төгрөг буюу 65 хувь буюу 21,541.6 мянган төгрөгөөр орлого дутуу орсон байна.
- Баянтал сумын нэгтгэлийн/ОН/ төлөвлөгөө 667,683.9 мянган төгрөг, гүйцэтгэл 380,335.9 мянган төгрөг байна. Үүнээс үндсэн цалин,унаа хоол,нэмэгдэл урамшуулалд 127,937.4 мянган төгрөг НДШ 11,123.6 мянган төгрөг зарцуулсан байна.
- Баянтал сумын нэгтгэлийн /ОН/ өглөг 32,839.3 мянган төгрөг , авлага 3,576.8 мянган төгрөг байна.
- Тайлант онд өглөгийн үүссэн шалгаан нь 2022 оны 1-4 сарын байдлаар Халаалт, цэвэр бохир усны үнэ нэмэгдснээс болж 22,313.6 мянган төгрөгөөр өглөг нэмэгдсэн байна.

Сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын ээлжит бус 09 дүгээр хуралдаан 2022 оны 05 дугаар сарын 03-ны өдөр болж Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан болон Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын дүгнэлтийг танилцуулан ажиллаа.


Сумын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зөвлөл 05 дугаар сарын 19-20-ны өдрүүдэд 5 хүний бүрэлдэхүүнтэйгээр сумын 2 дугаар багийн иргэд малчидтай тойрон уулзлав. Уулзалтын хүрээнд малчдын санал санаачлагын сонсох, хамтран ажиллах, авто тээврийн хэрэгсэл жолоодох эрхийн үнэмлэхгүй иргэдийг үнэмлэхжүүлэх, цахим хэрэглээ, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай мэдээ мэдээллийг хүргэв.



2022 оны 05 дугаар сарын 11-ний өдөр сумын 1-р багийн иргэдийн нийтийн хурал . Багийн иргэдийн нийтийн хурлын даргаар Ш.Шинэбаяр, багийн Засаг даргаар Э.Түмэн-Эрдэнэ. Багийн иргэдийн нийтийн хурлын тэргүүлэгчдээр Баттунгалаг, М.Ууганбаатар, Энхсайхан, нар сонгогдлоо.



Гурван сумдын Орон нутгийн хөгжлийн сангийн “САЙН ТУРШЛАГА” судлах арга хэмжээнд 100 хувийн ирцтэйгээр оролцож сайн туршлага судласан.



Худалдан авалт ба Орон нутгийн хөгжлийн сан:

1. 2022 оны 05 дугаар сарын 04-ний өдөр зарласан “Иргэдэд үйлчлэх төвийн тоног төхөөрөмж”, “152, 154-р байрны хажуу талд болон 154-р байрны 3, 4, 5 дугаар орцны гадна талд автозогсоол хийх” тендерүүдийг 05 дугаар сарын 13-ны өдөр нээхэд тус тус нэг нэг хуулийн этгээд оролцохоор Тендерийн баримт бичгээ ирүүлсэн. “иргэдэд үйлчлэх төвийн тоног төхөөрөмж” нийлүүлэх тендерт “Эргэл хийц” ХХК сайн үнэлэгдэн шалгарч 05 дугаар сарын 23-ны өдөр гэрээ байгуулна. “152, 154-р байрны хажуу талд болон 154-р байрны 3, 4, 5 дугаар орцны гадна талд автозогсоол хийх” тендерт “Хөгжих лүн тал” ХХК нь шалгуур үзүүлэлтийг хангаагүй тул дахин зарлахаар болсон.
 2. Наадмын талбай засварлах, шинэчлэх тендерийн зураг төсвийг хийлгүүлэхээр “Баярмега сервис” ХХК-тай 4,400,000 мянган төгрөгийн гэрээ байгуулж, урьдчилгаа 50 хувь болох 2,200,000 мянган төгрөг шилжүүлсэн.
 3. 2022 оны 05 дугаар сарын 20-ны өдөр LEXUS470 автомашины дуудлага худалдаа амжилтгүй болж дахин хуулийн хугацаанд зарлахаар болсон.
- /LEXUS470 автомашин нь иргэн хүний нэр дээр бүртгэлтэй, 20,000 төгрөгийн торгуультай, улсын дугаар нь солигдсон байсан тул дуудлага худалдааг хойшлуулав./



Хөдөө аж ахуйн ажлын хүрээнд:

МАЛ ТӨЛӨЛТ, ТӨЛ БОЙЖИЛТЫН МЭДЭЭ

2022 оны 05 дугаар сарын 23 -ны өдрийн байдлаар:

Нэр	Төлөх эх мал	Төлөлсөн эх мал	Хүлээн авсан төл					Төллөлтийн хувь	Бойжилтын хувь
Баянтал сум	27380	23444	23634					Бог малын төлөлт 98%, Бод малын төлөлт 72%	100%
			Ботго7	Унага281	Тугал283	Хурга14643	Ишиг-8543		



ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВ

Товлолт вакцинд
0-2 насны 6
хүүхэд
хамрагдсан

Ковидын
эсрэг
вакцин-0

Ковидын
өвчлөл-0



Урьдчилан
сэргийлэх
үзлэгт

6-45 насны 30
иргэн
хамрагдсан.



Хэвтэн
эмчлүүлэгч-5
иргэн



СУМ ХӨГЖҮҮЛЭХ САН

сүм хөгжүүлэх сан:

Сүм хөгжүүлэх сангийн 3 зээлдэгчийн 6,300,000 төгрөгийн өрийг 2022 оны 05 дугаар сард бүрэн барагдуулж дуусгасан.

сүм хөгжүүлэх сангаас зээлтэй эргэн төлөхгүй байгаа 2 зээлдэгчийн 15,700,000 мянган төгрөгийн зээлийг говьсүмбэр аймаг дахь иргэний анхан шатны шүүхэд хугацаа хэтэрсэн зээлчдийг өгсөн.




ТАЙЛАН ХЯНАСАН:

ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА  В. ГАНТУЯА

ТАЙЛАН НЭГТГЭСЭН:  8572

ХУУЛЬ ЭРХ ЗҮЙ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН

 М.БОДЬГЭРЭЛ